

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024//268/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секьюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/141
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
О.ДОЛЖИНСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Лүн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 8 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 83,2 хувиар хэрэгжүүлсэн байна

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт дунд

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,794,318.73	91,178,065.18
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	43,964,818.73	82,258,835.18
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	43,964,818.73	82,258,835.18
31210	Төгрөг	43,964,818.73	82,258,835.18
31211	Төрийн сангийн харилцах	43,957,618.73	82,258,835.18
31213	Арилжааны банк дахь харилцах	7,200.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,829,500.00	8,919,230.00
35100	Түүхий эд материал	2,500,000.00	0.00
35110	Тусгай зориулалттай материал	2,500,000.00	0.00
35400	Хангамжийн материал	16,329,500.00	8,919,230.00
35410	Бичиг хэргийн материал	163,000.00	139,200.00
35420	Аж ахуйн материал	12,002,851.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	4,163,649.00	8,780,030.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	361,865,574.25	354,107,864.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	361,865,574.25	354,107,864.95
39200	Биет хөрөнгө	353,275,574.25	345,517,864.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	367,258,750.00	367,258,750.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-36,789,285.96	-42,920,833.62
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	41,855,615.75	40,459,987.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	-35,958,781.71	-32,613,384.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,171,212.50	42,998,432.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,991,749.37	-38,104,746.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,638,800.00	11,638,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,675,116.12	-4,965,269.64
39217	Ном	1,766,129.16	1,766,129.16
39300	Биет бус хөрөнгө	8,590,000.00	8,590,000.00
39301	Програм хангамж	433,333.00	433,333.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-433,333.00	-433,333.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,590,000.00	8,590,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	424,659,892.98	445,285,930.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	415,105.00	3,124,768.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	415,105.00	3,124,768.00
41300	Өглөг	415,105.00	3,124,768.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	415,105.00	3,124,768.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	424,244,787.98	442,161,162.13

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	424,244,787.98	442,161,162.13
51	Засгийн газрын хувь оролцоо	424,244,787.98	442,161,162.13
51100	Засгийн газрын оруулсан капитал	173,631,816.76	173,631,816.76
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	173,631,816.76	173,631,816.76
51200	Хуримтлагдсан үр дүн	8,825,371.11	26,741,745.26
51210	Өмнөх үеийн үр дүн	-417,360,704.11	8,825,371.11
51220	Тайлант үеийн үр дүн	426,186,075.22	17,916,374.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	241,787,600.11	241,787,600.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	424,659,892.98	445,285,930.13

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	788,565,016.90	455,882,080.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	386,924,341.52	2,121,680.00
120	Нийтлэг татварын бус орлого	386,924,341.52	2,121,680.00
120009	Бусад орлого	7,200.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	366,104,001.52	1,012,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	20,813,140.00	1,109,680.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	401,640,675.38	453,760,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	339,408,400.00	420,235,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	339,408,400.00	420,235,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,263,600.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,968,675.38	33,524,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,968,675.38	33,524,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	362,378,941.68	426,787,755.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	362,378,941.68	426,787,755.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,754,024.68	424,460,670.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,553,008.37	283,650,464.69
210101	Үндсэн цалин	164,693,976.83	208,590,518.84
210102	Нэмэгдэл	57,053,794.96	63,444,434.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	11,805,236.58	11,615,511.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,968,551.04	35,001,939.86

210201	Тэтгэврийн даатгал	19,854,175.46	24,135,999.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,335,785.08	2,845,076.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,868,628.19	2,276,002.46
210204	Ажилгүйдлийн даатгал	442,178.76	522,230.95
210205	Эрүүл мэндийн даатгал	4,467,783.55	5,222,630.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,002,483.00	33,822,382.86
210301	Гэрэл, цахилгаан	2,879,315.00	4,657,614.86
210302	Түлш, халаалт	28,123,168.00	29,164,768.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,819,990.00	0.00
210401	Бичиг хэрэг	571,750.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	1,974,350.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,290.00	0.00
2105	Нормативт зардал	40,718,700.00	46,624,050.00
210502	Хоол, хүнс	40,718,700.00	46,624,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,175,200.00	500,000.00
210604	Урсгал засвар	1,175,200.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,000.00	857,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	850,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,702,092.27	24,004,233.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,335,915.00	11,400,524.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,127,750.00	1,586,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,238,427.27	11,017,709.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,624,917.00	2,327,085.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,160,100.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,160,100.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,464,817.00	2,327,085.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,464,817.00	2,327,085.14
213404	Хөрөнгийн	0.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	426,186,075.22	29,094,324.15
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	11,177,950.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	11,177,950.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	426,186,075.22	17,916,374.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	401,647,875.38	453,760,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,200.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,200.00	0.00
120009	Бусад орлого	7,200.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	401,640,675.38	453,760,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	339,408,400.00	420,235,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	339,408,400.00	420,235,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,263,600.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,263,600.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,968,675.38	33,524,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,968,675.38	33,524,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	357,683,056.65	413,218,383.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357,683,056.65	413,218,383.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,058,139.65	410,891,298.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,578,529.60	283,650,464.69
210101	Үндсэн цалин	147,950,453.20	198,082,760.29
210102	Нэмэгдэл	73,822,839.82	73,952,192.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	11,805,236.58	11,615,511.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,930,427.05	35,001,939.86
210201	Тэтгэврийн даатгал	19,777,545.08	24,135,999.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,322,688.48	2,845,076.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,858,130.75	2,276,002.46
210204	Ажилгүйдлийн даатгал	447,846.32	522,230.95
210205	Эрүүл мэндийн даатгал	4,524,216.42	5,222,630.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,002,483.00	30,697,614.86
210301	Гэрэл, цахилгаан	2,879,315.00	4,657,614.86
210302	Түлш, халаалт	28,123,168.00	26,040,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	0.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	0.00
2105	Нормативт зардал	41,042,700.00	46,624,050.00
210502	Хоол, хүнс	41,042,700.00	46,624,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	500,000.00
210604	Урсгал засвар	0.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,000.00	857,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	850,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,586,500.00	13,559,629.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,886,500.00	11,939,829.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,700,000.00	1,619,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,624,917.00	2,327,085.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,160,100.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,160,100.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,464,817.00	2,327,085.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,464,817.00	2,327,085.14
213404	Хөрөнгийн	0.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	43,964,818.73	40,542,016.45
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	2,248,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	2,248,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	2,248,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-2,248,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	43,964,818.73	38,294,016.45
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	43,964,818.73
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43,964,818.73	82,258,835.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	173,631,816.76	241,787,600.11	-417,360,704.11	-1,941,287.24
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	173,631,816.76	241,787,600.11	-417,360,704.11	-1,941,287.24
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	426,186,075.22	426,186,075.22
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,631,816.76	241,787,600.11	8,825,371.11	424,244,787.98
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	173,631,816.76	241,787,600.11	8,825,371.11	424,244,787.98
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	173,631,816.76	241,787,600.11	8,825,371.11	424,244,787.98
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	17,916,374.15	17,916,374.15
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	173,631,816.76	241,787,600.11	26,741,745.26	442,161,162.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	464,183,300.00	381,934,483.55	82,248,816.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	464,183,300.00	381,934,483.55	82,248,816.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	464,183,300.00	381,934,483.55	82,248,816.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	344,758,800.00	283,650,464.69	61,108,335.31
210101	Үндсэн цалин	230,930,900.00	198,082,760.29	32,848,139.71
210102	Нэмэгдэл	103,934,700.00	73,952,192.75	29,982,507.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	0.00
210104	Урамшуулал	9,893,200.00	11,615,511.65	-1,722,311.65
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,094,700.00	35,001,939.86	8,092,760.14
210201	Тэтгэврийн даатгал	29,304,300.00	24,135,999.80	5,168,300.20
210202	Тэтгэмжийн даатгал	3,447,700.00	2,845,076.12	602,623.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,758,100.00	2,276,002.46	482,097.54
210204	Ажилгүйдлийн даатгал	689,400.00	522,230.95	167,169.05
210205	Эрүүл мэндийн даатгал	6,895,200.00	5,222,630.53	1,672,569.47
2105	Нормативт зардал	58,838,800.00	46,624,050.00	12,214,750.00
210502	Хоол, хүнс	58,838,800.00	46,624,050.00	12,214,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	955,900.00	850,400.00	105,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	955,900.00	850,400.00	105,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,535,100.00	15,807,629.00	727,471.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,667,300.00	12,939,829.00	727,471.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,867,800.00	2,867,800.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	464,183,300.00	420,235,700.00	43,947,600.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	420,235,700.00	420,235,700.00	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	420,235,700.00	420,235,700.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	43,947,600.00	0.00	43,947,600.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	43,947,600.00	0.00	43,947,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.00	43,964,818.73	-43,964,818.73
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.00	82,258,835.18	-82,258,835.18

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Лүн сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Лүн сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оныг "Ёс зүйн харьцаа хандлагыг дээшлүүлэх" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 8 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 83,2 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 18 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

2023 он 11 сард Төв аймгийн засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтанд 80,2 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Лүн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Лүн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023. оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,626.0 мянган төгрөгөөр буюу 4,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	43,964.8	82,258.8	38,294.0
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	18,829.5	8,919.2	-9,910.2
Үндсэн хөрөнгө	361,865.5	354,107.9	-7,757.6
Нийт хөрөнгө	424,659.8	445,285.9	20,626,0
Өр төлбөр	415.1	3,124.7	2,709.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	173,631.8	173,631.8	
Дахин үнэлгээний зөрүү	241,787.6	241,787.6	
Хуримтлагдсан үр дүн	8,825.3	26,741.8	17,916.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	424,659.8	445,285.9	20,626.0

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 38,294.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь урд оны төсвийн гүйцэтгэлийн үлдэгдэл, мөнгөн хөрөнгө дансанд орж ирсэнээс шалтгаалан өссөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 9,910.2 мянган төгрөгөөр буурсан нь цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны 11 сарын 10-ний өдрийн А/25 тоот тушаалаар тусгай зориулалтын материал 620.0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 33.0 мянган төгрөг, аж ахуйн материал 7,894.2 мянган төгрөг, бусад хангамжийн материал 2,630.7 мянган төгрөг нийт 11,177.9 мянган төгрөгийн бараа материалыг актласнаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 7,757.6 мянган төгрөгөөр буурсан нь Лүн сумын ИТХ-н 2023 оны 03 сарын 29-ний өдрийн 04 тоот тогтоолоор тоног төхөөрөмж 4,655.6 мянган төгрөг, тавилга эд хогшил 13,172.8 мянган төгрөг нийт 17,828.4 мянган төгрөгийн хөрөнгийг актласнаас шаалтгаалсан байна.

Өглөг данс 2,709.6 мянган төгрөгөөр өссөн нь халаатын үнэ тарифийн зөрүүнээс /батлагдаж ирсэн төсөвт халаалтын үнэ хуучин тарифаар бодогдож ирсэний улмаас зөрүү гарснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 462,992,5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 33,524,7 мянган төгрөг нийт зарлагыг 496,517,2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 496,517,2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 496,517.2 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 462,992.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 33,524.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 413,139.2 мянган төгрөг буюу 82,5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 81,050.8 мянган төгрөгөөр, үүнээс цалин хөлс болон нэмэгдлийг 61,108.3 мянган төгрөгөөр, хоол хүнс 12,214.7 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлаас 7,913.8 тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,433.9	884.3	549.6	61.7
2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	58,838.8	46,624.0	12,214.7	79.2%
3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин		3,160.8	-3,160.8	100%
4	81823-Багш ажилтаны мэргэжил дээшлүүлэх	2,867.8	1,256.0	1,611.8	43.8%
5	81833 Явуулын багшийн үйлчилгээ	1,020.0	1,020.0		100%
6	81834 Боловсролын стандарт	288,521.1	243,582.2	44,938.9	84.4%
7	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	110,155.5	85,407.1	24,748.4	77.5%
8	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	33,524.7	31,197.6	2,327.1	93%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Лүн сумын Хүүхдийн цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	61,7%	1,433.9	884.3
2	71801-81807	2023-12-31	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	79,2%	58,838.8	46,624.0
3	71801-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%		3,160.8
4	71801-81823	2023-12-31	Багш ажилтаны мэргэжил дээшлүүлэх	43,8%	2,867.8	1,256.0
5	71801-81833	2023-12-31	Явуулын багшийн үйлчилгээ	100%	1,020.0	1,020.0
6	71801-81834	2023-12-31	Боловсролын стандарт	84,4%	288,521.1	243,582.2
7	71801-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	77,5%	110,155.5	85,407.1
8	71801-80111	2023-12-31	Тогтмол зардал	93%	33,524.7	31,197.6

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралттай холбоотойгоор хүүхдийн ирц багасдагтай холбоотойгоор хэмнэгдсэн. Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн. Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь хагас ажилчид урьд онд хамрагдсантай холбоотой.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу томуу төст өвчин ихэссэн, цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цахим дэлгүүрээс худалдан авалт байхгүй. Тендерт шалгарсан Мөнхийн Оюу Бадмаараг ХХК-с хүнс болон бусад материалаа худалдан авдаг.Мөн Монгол Шуудан ХХК-тай шууд гэрээтэй

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана”

гэж заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Лүн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 355,000.0 мянган төгрөгнөөс 2.0 хувиар буюу 7,100.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,680.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Лүн сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 107,743.4 мянган төгрөгөөр
- Бүх төрлийн даатгалын зардлыг 10,811.5 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 5,334.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус цэцэрлэг нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 158 мэдээллийг байршуулж 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулав.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн ба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт 1, албан шаардлага 1, зөвлөмж 1 авсан бөгөөд биелэлтийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Лүн сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 966.3 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах зөвлөмж өгч ажиллаа. Завсрын аудитын зөвлөмжийн биелэлтийг жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж хэрэгжиж 2 зөвлөмж хэрэгжээгүй тул аудитын тайланд зөрчлөөр орууллаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	798.0	1	798.0	100
Албан шаардлага	1	415.1	1	415.1	100
Зөвлөмж	1		1		100
Нийт дүн	3	1,213.0	3	1,213.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал ажиглагдсангүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 966.3 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 966.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбрийн акт

5.2 Албан шаардлага

5.3 Зөвлөмж

1.Зардлын данстай холбоотой асуудал

Батлагдсан жишиг нормыг баримталж ажиллаагүйн улмаас 129.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 сарын 02 өдрийн А/166 дугаартай хамтарсан тушаалын 2-р заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид дээрхи тушаалд дурдсан хоолны орц нормыг баримтлан ажиллахыг ахлах тогооч мөрдөж, нягтлан бодох хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөв.

2.Зардлын данстай холбоотой асуудал

Илүү цаг болон хавсран ажиллсан цалин тооцохдоо анхан шатны баримт бүрдүүлээгүйн улмаас 837.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид тухайн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх албан шаардлага болон зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Илүү цаг болон хавсран ажиллсан цалин тооцохдоо анхан шатны баримт бүрдүүлээгүй	1	837.0					1	837.0				
Батлагдсан жишиг нормыг баримталж ажиллаагүй	1	129.3					1	129.3				
Дүн	2	966.3					2	966.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn